

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

ГОМБО-ИЧИНГИЙН ДОРЖХАНД

**ЭМШУИС-ИЙН БАГШ, ОЮУТАН, АЖИЛТАН, АЖИЛЧДЫН ДУНДАХ
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН
ТАРХАЛТЫН СУДАЛГАА**

Е-725600 – Нийгмийн эрүүл мэнд

Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

Улаанбаатар хот

2010 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

ГОМБО-ИЧИНГИЙН ДОРЖХАНД

**ЭМШУИС-ИЙН БАГШ, ОЮУТАН, АЖИЛТАН, АЖИЛЧДЫН ДУНДАХ
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН
ТАРХАЛТЫН СУДАЛГАА**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Анагаах Ухааны доктор (Ph.D), профессор О.Чимэдсүрэн

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

Академич, АШУ-ны доктор (Ph.D), профессор

Ц.Лхагвасүрэн

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Анагаах Ухааны доктор (Ph.D) Д.Мягмарцэрэн

Улаанбаатар хот

2010 он

ТОВЧ ХУРААНГУЙ

Судалгааны ажлын үндэслэл: Сүүлийн жилүүдэд дэлхийн хүн амын өвчлөл, эндэгдэлийн бүтцэд тэдний амьдралын хэв маяг тухайлбал зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи тамхины хэрэглээнээс хамааран үүсдэг халдварт бус өвчин (ХБӨ) тэргүүлэх байр суурийг эзлэх болов. Нэн ялангуяа зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин зэрэг өвчнөөр өвчлөгсдийн тоо хурдацтай өсөн нэмэгдэж хүн амын эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон нь нийгмийн эрүүл мэндийн нэн чухал анхаарал татсан асуудлын нэг болж байна.

Судалгааны зорилго: Бид уг судалгааг ЭМШУИС-ийн багш, оюутан, ажилтан, ажилчдын эрүүл мэндийн байдлыг үнэлэн, тэдний дундах ХБӨ-ний зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судлах зорилгоор явуулсан.

Судалгааны загвар арга зүй: Судалгааг агшингийн судалгааны аргаар хийж гүйцэтгэлээ. ЭМШУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудийн 209 багш, ажилтан, ажилчид, 386 оюутанг тус судалгаанд хамруулав.

Судалгааны асуумж нь 7 бүлэг бүхий 73 асуултаас бүрдсэн бөгөөд ерөнхий хэсэг, хүн ам зүйн үзүүлэлт, хорт зуршлын хэрэглээ, хооллолт, хөдөлгөөний талаарх бүлэг асуултуудыг багтаасан асуумжийг ашиглан мэдээлэл цуглуулсан. Тоон судалгааны мэдээллийг оруулж, үр дүнгийн шинжилгээ хийн, мэдээлэл боловсруулахад SPSS 12 программ ашиглав. Судалгаанд оролцогчдын ерөнхий шинжийг дескриптив судалгааны аргаар шинжлэн дундаж, түүний хазайлт, дээд ба доод утгуудыг тооцов. Мөн цусны даралт, биеийн өндөр жин, бусад үзүүлэлтийн хоорондын ялгааг ONE WAY ANOVA тестийн арга ашиглан тооцсон.

Үр дүн: Судалгаанд нийт 20-69 насны 209 багш, ажилтан, ажилчид хамрагдсанаас багш 57,9%, ажилтан, ажилчид 42.1%, үүнээс 70,8% нь эмэгтэй, 29.2% нь эрэгтэй, мөн 20-30 насны нийт 386 оюутан хамрагдсанаас, хүйсний хувьд 79.8% нь эмэгтэй, 20.2% нь эрэгтэй оюутнууд эзлэж байлаа.

Судалгаанд хамрагдсан багш, ажилтан, ажилчдын 13.4%, оюутнуудын 7.9% нь тамхи татдаг, энэ нь эрэгтэй хүйсэнд илүү байв.

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан багш нарын идэвхтэй хөдөлгөөн хангалтгүй буюу нэлээд цагийг (4.6 цаг) идэвхтэй хөдөлгөөн багатай суугаа байрлалд өнгөрүүлдэг байна. Эрүүл мэндийн ерөнхий үзүүлэлтүүд хэвийн үзүүлэлттэй байгаа боловч багш, ажилтан, ажилчдын 63.1%, оюутнуудын 12.3% жингийн илүүдэл болон таргалалттай байна. Судалгаанд хамрагдагсадын 3 хүн тутмын 1 нь ХБӨ-ний ямар нэг эрсдэл илэрсэн бөгөөд багш, ажилтан, ажилчдад 6 хүн тутмын 1, оюутнуудын 1/10-д 3 ба түүнээс дээш эрсдэл хавсран тохиолдолж байна.

Судалгаанд хамрагдсан багш, ажилтан, ажилчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан дүгнэлтээс харахад тэдний дунд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, бөөр, шээсний замын, оюутнуудын дунд дийлэнх шүдний ямар нэг хэлбэрийн цооролт гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл, залгиурын үрэвсэл 13.25% тус тус давамгайлж байна.

Түлхүүр үг: Халдварт бус өвчин, багш, оюутан, биеийн жингийн индекс

ABSTRACT

Background: Leading causes of mortality in people are cardiovascular diseases, cancer and diabetes which are caused by individuals' behavior and lifestyle and prevalence of these diseases are having a tendency to increase more in the future.

Objectives: The main goal of survey were to evaluate of health status of HSUM teachers, students and workers healthy status the prevalence of some risk factors for NCDs among them.

Methods: The survey was designed by analytic study's cross-sectional design. Teachers, student and workers of the branch schools of HSUM were involved in this study. 209 teachers workers and 386 students were involved in the study.

Data was collected using a structured 7 chapters with 73 questionnaire/ questions including general section, demographic index, tobacco and alcoholic consumption, nutritional habit, physical activity questions.

SPSS 12 program was used to insert quantitative analysis data, perform result analysis and process information. General characteristics of study-participants were measured by descriptive analysis and mean, deviation, minimum and maximum values were estimated. Difference between indicators blood pressure, body weight and height were compared by ANOVA test method.

Results: Overall 209 teachers and workers were participated in our survey which 70.8% of them was female were and 29.2% were males. Among these records, were teachers 57, 9% and 42, 1% were workers. Teachers and workers were aged between 20 and 69. Overall 386 teachers and workers were participated in our survey which 79.8% of them was female were and 20.2% were males, were aged between 20 and 30. Of the study participants teachers and workers 13.4%, students 7.9% of study involved people were smokers. Males had statistically significant higher rate of smoking prevalence.

Prevalence of alcohol consumption teachers and workers was 64.9%, students 61.5% according the past 1 year. Alcohol consumption rate was lower in females than males. In terms of age group, alcohol consumption rate decreased across the age increase.

Conclusion: The amount of time spent on sitting still was higher (4.6 qar) than the amount of time spent on physical activity.

From the result of above table, even though the general health status indicators were within normal limits, 63.1% of teachers and workers were overweight and obesity. Percentage of overweight students were comparatively low (12.3%).

In the survey revealed that 9 in every 10 people had at least one risk factors for developing NCDs. One in every six people had three and more risk factors in developing

NCDs. From overall study involved teachers and workers, prevalence of gastrointestinal(28.78%) and urinary tract (14%) disorders were dominantly observed. Results of research, 8 in 10 students had some degree of caries, 75.86% of students had chronic tonsillitis and 13.25% of students had pharyngitis.

Key words: Non communicable diseases, teacher, student, body mass index

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАСААЛТ.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ	
1.1. Судалгааны ажлын үндэслэл.....	7
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт.....	8
1.3. Судалгааны ажлын шинэлэг тал.....	8
1.4. Судалгааны ажлын практик ач холбогдол.....	9
1.5. Судалгааны ажлын хэлэлцүүлсэн байдал.....	10
1.6. Судалгааны ажлын хэвлүүлсэн байдал.....	10
БҮЛЭГ 2. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	
2.1. ХБӨ-ний тархалт, дэлхий дахин дахь байдал.....	11
2.2. Монгол улс дахь ХБӨ-ний өнөөгийн байдал	16
2.3. ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлс.....	17
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	
3.1. Судалгааны загвар	24
3.2. Судалгааны хүрээ ба түүвэр.....	26
3.3. Судалгааны ажлын материал цуглуусан аргууд	25
3.4. Судалгааг хийсэн аргачлал.....	26
3.5. Үр дүнгийн статистик боловсруулалт	29
БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН	
4.1. ХБӨ-ний зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тодорхойлсон дүн.....	29
4.2. Судалгаанд хамрагдагсадын эрүүл мэндийн үзлэг,	

шинжилгээний дүн	46
БҮЛЭГ 5. ХЭЛЦЭМЖ.....	52
БҮЛЭГ 6. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	58
НОМ ЗҮЙ	60
ТАЛАРХАЛ.....	67
ХАВСРАЛТ.....	68